



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/339

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Нийслэлийн Төр захиргааны авто бааз” УТҮГ-ын балансад бүртгэлтэй, Хьюндай старекс маркийн УНА 07-12 улсын дугаартай тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлэн, данс бүртгэлээсээ хасахыг “Нийслэлийн Төр захиргааны авто бааз” УТҮГ (Э.Болор-эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

2.Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу бүртгэн авч, өмчийн ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар (Л.Дэлгэр)-т үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т даалгасугай.


НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



1110201454

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 18-ны өдрийн
дугаар захирамжийн хэвсрэлт



БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

№	Хөрөнгийн нэр	Улсын дугаар	Нийт гүйлт км	Арлын дугаар	Ашиглалтад авсан он	Тоо ширхэг	Бүртгэлийн үнэ (2022 онд дахин үнэлсэн)	Хуримтлагдс ан элэгдэл	Үлдэх өртөг	Өмч эзэмшигч байгууллагын нэр	Шилжүүлэх байгууллага
1	Хьюндай старекс	07-12 УНА	166114	KMJWA37RADU568625	2015	1	40,800,000.00	40,006,666.71	793,333.29	Нийслэлийн Төр захиргааны авто бааз	Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар
Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн							40,800,000.00	40,006,666.71	793,333.29		